



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Био асралт ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/244/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга: Г.Нандинжаргал
Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn
Санхүүгийн аудитын албаны ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Санхүүгийн аудитын албаны аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 11315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn
Авера аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Нарантуяа
Утас: 99133545 Цахим хаяг: avera.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

- 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ
- 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Био асралт ӨЭМТ-ийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог 20-оор баталж, тайлант онд 15 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамж 85.5 хувь, ЭМДЕГ-аас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний биелэлт 96.3 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025.01.01.	2025.12.31.
1	<u>ХӨРӨНГӨ</u>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	603,012.77	657,431.81
1.1.2	Дансны авлага	23,823,530.55	4,723,322.60
1.1.6	Бараа материал	35,246,680.00	34,712,575.25
1.1	Эргэлтийн хөрөнгийн дүн	59,673,223.32	40,093,329.66
1.2.1	Үндсэн хөрөнгө (цэвэр)	253,740,601.43	241,990,350.78
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	253,740,601.43	241,990,350.78
1.3	НИЙТ ХӨРӨНГӨ	313,413,824.75	282,083,680.44
2.1.1	<u>Богино хугацаат өр төлбөр</u>	10,077,562.00	13,200,000.00
2.1.1.3	Татварын өглөг	6,349,562.00	
2.1.1.10	Бусад өглөг	3,728,000.00	13,200,000.00
2.2	Нийт өр төлбөр	10,077,562.00	13,200,000.00
2.3	<u>Эздийн өмч :</u>		
2.3.1	Өмч-төрийн	40,075,783.83	40,075,783.83
2.3.2	-хувийн	1,170,800.00	1,170,800.00
2.3.9	Хуримтлагдсан үр дүн	259,957,147.02	259,957,147.02
2.3.10	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,132,531.90	2,132,531.90
	Тайлант үеийн		(34,452,582.31)
2.3.11	Эздийн өмчийн дүн	303,336,262.75	268,883,680.44
2.4	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	313,413,824.75	282,083,680.44

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025.01.01.	2025.12.31.
1	Борлуулалтын орлого(цэвэр)	415,898,639.95	412,223,487.20
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	415,898,639.95	412,223,487.20
5	Хүүний орлого		30,742.51
8	Бусад орлого	99,658,734.77	43,549,735.10
10	Ерөнхий удирдлагын зардал	461,913,403.00	490,256,547.12
18	Татварын өмнөх ашиг (алдагдал)	53,643,971.72	(34,452,582.31)
19	Орлогын албан татварын зардал		
20	Тайлант жилийн татварын дараах ашиг (алдагдал)	53,643,971.72	(34,452,582.31)
22	Тайлант үеийн цэвэр ашиг		
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	53,643,971.72	(34,452,582.31)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025.01.01.	2025.12.31.
1	1.Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	409,204,241.17	439,062,994.26
	Татаас санхүүжилтийн орлого	409,097,176.40	430,122,195.15
	Бусад орлого	107,064.77	8,940,799.11
1.2	1.2 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	411,796,565.07	428,908,575.22
	Ажиллагсдад төлсөн мөнгө	296,134,039.00	313,924,516.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	26,913,264.15	23,052,709.92
	Бараа материал худалдан авахад төлсөн	19,244,070.00	63,203,049.00
	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	4,861,035.44	4,622,362.52
	Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	2,031,500.00	1,902,500.00
	Бусад мөнгөн зарлага	62,612,656.48	27,253,437.78
1.3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(2,592,323.90)	5,104,419.04
2	2.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	2.1 Мөнгөн орлогын дүн	-	-
2.2	2.2 Мөнгөн зарлагын дүн	-	5,050,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		5,050,000.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	(5,050,000.00)
3	3.Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,592,323.90)	54,419.04
6	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,195,336.67	603,012.77
7	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	603,012.77	657,431.81

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт
1	2024 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	40,075,783.83	2,132,531.90	206,313,175.30	248,521,491.03
3	Залруулагдсан үлдэгдэл	40,075,783.83	2,132,531.90	206,313,175.30	248,521,491.03
4	Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)	-		53,643,971.72	248,521,491.03
5	Өмчид гарсан өөрчлөлт	1,170,800.00			1,170,800.00
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-		-	-
8	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	41,246,583.83	2,132,531.90	259,957,147.02	303,336,262.75
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-			-
10	Залруулагдсан үлдэгдэл	41,246,583.83	2,132,531.90	259,957,147.02	303,336,262.75
12	Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)	-		(34,452,582.31)	(34,452,582.31)
15	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	41,246,583.83	2,132,531.90	225,504,564.71	268,883,680.44

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 69,630.1 мянган төгрөгийн 5 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж баталгаажуулсан. Үүнд:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд 30.7 мянган төгрөгийн орлогыг ангилал зөрүүтэй тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд 8,910.1 мянган төгрөгийн орлогыг ангилал зөрүүтэй тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд 42,439.3 мянган төгрөгийн зардлыг ангилал зөрүүтэй тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд 5,050.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах зардлыг дутуу тайлагнасан;
- Тайлант онд үүссэн 13,200.0 мянган төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй зэрэг алдааг залруулав.

Энэ нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” болон санхүүгийн тайлагналын “*толилуулга ба тодруулга*”, “ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 7,414.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 5,646.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1,767.17 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 7,414.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Үйл ажиллагааны зардлаас 2,800.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 03 тоот тогтоол "Өрх,сум,тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж,үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх,хяналт тавих журам"-ын 3.7-д"Өрх,сум,тосгоны эрүүл мэндийн төвд хуваарилсан санхүүжилтийг зориулалт бус,хөтөлбөр,арга хэмжээнд зарцуулахыг хориглоно."заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бус зарцуулсан зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2.Гэрээт ажилтнуудад 2,846.4 мянган төгрөгийн ээлжийн амралтын хөлс олгосон байна. Энэ нь “Нөхөрлөлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д “Удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүдийн болон нөхөрлөлийн үйл ажиллагаанд бусад гишүүд хяналт тавина.”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Гэрээт ажилтнуудад ээлжийн амралт олгосон зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй болсон (192,604.2 мянган төгрөг) хөрөнгийн ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн эдийн засгийн нас буюу эдийн засгийн өгөөжид үндэслэн тогтоож дахин үнэлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох;” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “толилуулга ба тодруулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхөж үлдэх өртөггүй болсон хөрөнгийг дахин үнэлэх хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

2.Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Ээлжийн амралтын тушаалд амрах хоногийг буруу оруулснаас 1 хүнд 284.6 мянган төгрөгийг дутуу, 4 хүнд 1,483.1 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “толилуулга ба тодруулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ээлжийн амралтын тушаалд амралтын хоногийг зөв оруулж, ээлжийн амралтын олговрыг үнэн зөв тооцож олгох зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлогын дэлгэрэнгүй тайланд 30.7 мянган төгрөгийн орлогыг ангилал зөрүүтэй тайлагнасан	1	30.7			1	30.7	1	30.7		
Мөнгөн гүйлгээний тайланд 8,910.1 мянган төгрөгийн орлогыг ангилал зөрүүтэй тайлагнасан.	1	8,910.1			1	8,910.1	1	8,910.1		
Мөнгөн гүйлгээний тайланд 42,439.3 мянган төгрөгийн зардлыг ангилал зөрүүтэй тайлагнасан.	1	42,439.3			1	42,439.3	1	42,439.3		
Мөнгөн гүйлгээний тайланд 5,050.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах зардлыг дутуу тайлагнасан.	1	5,050.0	1	5,050.0			1	5,050.0		
Тайлант онд үүссэн 13,200.0 мянган төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1	13,200.0	1	13,200.0			1	13,200.0		
Дүн	5	69,630.1	2	18,250.0	3	51,380.1	5	69,630.1	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй болсон (192,604.2 мянган төгрөг) хөрөнгийг дахин үнэлээгүй байна.	1	-					1	-		
Үйл ажиллагааны зардлаас 2,800.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	2,800.0			1	2,800.0	0	-		

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Био асралт ӨЭМТ-ийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Гэрээт ажилтнуудад 2,846.4 мянган төгрөгийн ээлжийн амралтын хөлсийг олгосон байна.	1	2,846.4			1	2,846.4	0	-		
Ээлжийн амралтын тушаалд амрах хоногийг буруу оруулснаас 1 хүнд 284.6 мянган төгрөгийг дутуу, 4 хүнд 1,483.1 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	1,767.7					1	1,767.7		
Дүн	4	7,414.1	-	-	2	5,646.4	2	1,767.7		



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 398/Б.1000178

Улаанбаатар хот

НТАГ-2026/244/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хан-Уул дүүргийн Био асралт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэрээт ажилтнуудад 2,846,400.00 (хоёр сая найман зуун дөчин зургаан мянга дөрвөн зуун) төгрөгийн ээлжийн амралтын цалин олгосон байна.

Энэ нь Нөхөрлөлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д "Удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүдийн болон нөхөрлөлийн үйл ажиллагаанд бусад гишүүд хяналт тавина", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Гэрээт ажилтнуудад ээлжийн амралтын нөхөн олговор олгосон зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн Био асралт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Д.Нарантуяа, нягтлан бодогч Т.Ганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АВЕРА АУДИТ ХХК-НИЙ ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Г.НАРАНТУЯА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090773



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 339/Б/000178

Улаанбаатар хот

НТАГ-2026/244/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хан-Уул дүүргийн Био асралт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагааны зардлаас 2,800,000.00 (хоёр сая найман зуун) төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 03 тоот тогтоол " Өрх,сум,тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж,үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ын 3.7-д "Өрх,сум,тосгоны эрүүл мэндийн төвд хуваарилсан санхүүжилтийг зориулалт бус,хөтөлбөр ,арга хэмжээнд зарцуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д" батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" заасныг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс зориулалт бус зарцуулсан зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн Био асралт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Д.Нарантуяа, нягтлан бодогч Т.Ганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АВЕРА АУДИТ ХХК-НИЙ ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Г.НАРАНТУЯА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090777